

Залуу үеийн боловсрол, төлөвшилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь

Д.Энхжаргал*

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль

Хураангуй

Энэхүү илтгэлийн хүрээнд хүүхдийн боловсрол төлөвшилд өнөөгийн эцэг эхийн оролцоо чухам ямар байгаа, тэдний оролцоог чанаржуулахын тулд юу хийх ёстойг авч үзэхийг зорьсон болно. Энэ судалгааг хийхдээ бид нийт 120 эцэг эх, хүүхдүүдээс асуулга, ярилцлага авч үр дүнг боловсрууллаа. Судалгааны дүнгээс харахад үр хүүхдээ хүмүүжүүлж боловсруулна гэдэг нь төр засаг, сургалтын байгууллагуудад хамаарах үүрэгтэй ажил гэж ойлгодог хандлага хэвээр байгаа нь харагдаж байна. Тэрчлэн нэгэнт эцэг эх болсон бол төрүүлсэн үр хүүхдээ хүмүүжүүлж төлөвшүүлэх нь чухал гэдгийг ойлгодог боловч бодит ажил хэрэг болгоход чиглэл зорилготой үйлийг хийж чаддаггүй нь судалгаанаас харагдсан юм. Мөн эцэг эхүүд төр, засгийн зүгээс илүү анхаарч ажиллах ёстой гэж үзэж байхад хүүхдүүдийн хувьд хүүхэд өөрөө өөртөө илүү анхаарах ёстой гэсэн дүгнэлтийг өгсөн нь сонирхолтой байлаа. Юутай ч эцэг эхийн хувьд цаг заваа зөв ашиглаж, хүүхдүүдтэйгээ ойр дотно хамтран ажиллаж, эерэг нөлөө үзүүлж чадах арга хэрэгслийг нас сэтгэхүйд нь тохирсон олон хувилбараар сонгон ажиллах чадвартай байхыг эрхэмлэх хэрэгтэй байна. Эцэг эхийн үг үйлдэл бүхэн хүүхдийн төлөвшил, боловсролд онцгой нөлөөлдгийг ухамсарлаж, хүүхдийнхээ нас, бие, сонирхол, сэтгэлгээний онцлогийг өөрсдийн ажил, амьдрал, боломжтой уялдуулан хүүхдэдээ чиглэсэн харилцаандаа шинэлэг, хариуцлагатай хандах нь эцэг эхийн өмнө тавигдаж буй өнөөгийн шаардлага болж байна.

Түлхүүр үг

Залуу үеийн боловсрол, төлөвшил, эцэг эхийн оролцоо

Удиртгал

Залуу үеийн боловсролын асуудал өнөөгийн нийгмийн онцгой асуудал. Үүнд онцгой үүрэгтэй хүмүүс бол гарцаагүй эцэг эх. Үр хүүхдээ зөв хүн болгон хүмүүжүүлэх, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэхэд анхдагч орчин болсон гэр бүл чухал үүрэгтэй.

Өөрчлөлт шинэчлэлт эхэлсэн цаг үеэс боловсролын салбарын өөрчлөлтийг онцгойлон анхаарч, ирээдүйн иргэдийг бэлтгэх хамгийн чухал үүргийг зөвхөн сургууль, багш нарт даатгаж ирсэн хуучин сэтгэлгээнээсээ салж, эцэг эх хүүхдээ сургах ажил үйлд өөрсдөө гол хүч болж оролцохыг чухалчилж байна.

Монгол түмний хөгжүүлж ирсэн боловсролын замналд хүнийг хүн болгох гайхамшигтай өв ухаан уламжлагдаж ирсэн хөрсөн дээр орчин үеийн хөгжилтэй уялдсан боловсролын дэвшилтэт загварыг хөгжүүлэх нь өнөөгийн өөрчлөлт шинэчлэлийн чиг зорилго юм.

“Боловсролын өөрчлөлт шинэчлэлт гэдэг нь уг системийн дэвшилттэй талыг хөндөлгүйгээр зөвхөн доголдолтой хэсгийг нь засаж сайжруулах алхам юм” (Raymond A.Horn, Jr, 2002, p.2).

Судалгааны арга зүй


Амьдралын хэв маяг хурдтай өөрчлөгдөж, нийгмийн амьдралд хүндрэл бэрхшээл нэлээдгүй байгаа манай орны хувьд ирээдүй болсон хойч үеийнхээ асуудлыг үргэлж өмнөө тавьж, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлэх нь хүний хөгжлийн төдийгүй улс орны амин чухал асуудал юм. Эцэг, эх үр хүүхдээ зөв зүйтэй хүмүүжүүлж төлөвшүүлэхийг дэмжсэн үйл ажиллагааг Монголын төр төдийгүй боловсролын чиглэлийн аль ч түвшинд ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагууд явуулах нь үүрэг юм. Ялангуяа эцэг эхийн хувьд үр хүүхдийнхээ боловсрол хүмүүжилд эерэг сайнаар нөлөөлж чадах бодит нөхцөлийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх нь чухал болж байна. Энэ талаар төр олон нийт, боловсролын газрууд олон ажил хийж байгааг бид харж байна. Гэхдээ нөгөө талаас үр хүүхдийнхээ төлөө эцэг, эхийн идэвх чармайлтгүйгээр хүссэн үр дүнд хүрэх боломжгүй. Тиймээс эцэг эх чухам хүүхдийнхээ төлөө юу хийж байна, гэр бүлийн орчинд олж авах ёстой төлөвшлийг хүүхэд авч чадаж байна уу гэдгийг тодруулж, асуудал байвал шийдвэрлэх нь цааш ахих үндэс болох юм.

Энэхүү илтгэлийн хүрээнд хүүхдийн боловсрол төлөвшилд өнөөгийн эцэг эхийн оролцоо чухам ямар байгаа, тэдний оролцоог чанаржуулахын тулд юу хийх ёстойг авч үзэхийг зорьсон болно.

“Залуучуудын хүмүүжил, төлөвшлийн нэг эх сурвалж зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талуудыг олж харах, тэдгээр талуудыг сөргөлдүүлэх бус шүтэн барилдуулж, хувь хүний болон нийгмийн хүмүүжлийн зохист тэнцвэрийг олох нь хүмүүжил дэх зөрчилт байдлыг эергээр гэтлэх үндсэн зарчим, хандлага болно (Пүрэв, 2013, т. 162) гэсэн энэ үзэл хандлагын үүднээс эцэг эх, үр хүүхэд гэсэн хоёр талт харилцааг тус тусын өнцгөөс судалж асуудлыг илрүүлэхээр 56 эцэг эх (эцэг-15, эх-41), 18 хүртэлх насны 64 хүүхэд нийт 120 оролцогчоос асуулга болон ярилцлага авч үр дүнг боловсрууллаа. Асуулгад эцэг эхийн зүгээс хүүхдэд өдөрт хэдэн цагийг зарцуулдаг, юуг илүү голлон хөгжүүлэхийг зорьдог, үр хүүхдэд хүмүүжүүлэх өөрсдийн мэдлэгийг хэрхэн үнэлдэг болон тэдний хүүхдэд хандах хандлага, харилцааны чанарт тандах агуулгатай асуултуудад хариулт авч дүгнэв.


Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан эцэг эхээс өдөрт дунджаар хэдэн цагийг хүүхдэд зарцуулж чаддаг тухай асуухад оролцогчдын дийлэнх буюу 50 % нь 1 цаг, 15 % нь 4 цаг гэсэн байхад 14 % нь тусгайлан зориулсан цаг байдаггүй гэж хариулж байна.




Судалгааны үр дүнгээс харвал, бодит амьдрал дээр манай эцэг эхчүүдийн зонхилох хэсэгт үр хүүхдэд тавих анхаарал нь бага байгаа тодорхой байна. Үүний шалтгааныг ажил, амьдралын шаардлагаас хамаарч байна хэмээн тайлбарлаж байв. Мөн эцэг эхийн оролцоотой хийгдэх сургалтын бүтээлч даалгавар өгөхөд суралцагчид сайн гүйцэтгэж чадахгүй байх тохиолдол элбэг гардаг учир асуулгаар тандалт судалгаа хийсэн юм.

Та хүүхдийнхээ хичээл, даалгаврын талаар хэр зэрэг сонирхож ярилцдаг вэ?



Судалгаанд оролцсон эцэг эхийн 36 % нь хүүхдийнхээ даалгаврыг хаяа сонирхдог гэсэн байхад 43 % нь асуусан тохиолдолд анхаардаг, 21 % нь байнга даалгаврыг нь асууж ярилцдаг гэж хариулсан юм.


Та хүүхдийнхээ боловсролд анхаарал хандуулах өөрийн мэдлэг чадварыг хэрхэн үнэлж байна вэ?



Хүүхдийг хэрхэн хүмүүжүүлэх талаар өөрсдийн мэдлэг чадварыг үнэлэхдээ судалгаанд оролцогчдын 50% нь буюу дийлэнх нь “дунд”, 27 % нь сайн гэж дүгнэсэн нь анхаарал татаж байна. Хүүхэд залуусын боловсролд юуг илүү анхаарч хөгжүүлэхийг зорьдог тухай ярилцахад оролцогчид “сурах орчныг нь сайжруулахад”, “зөв хүмүүжилтэй болох” “эрүүл байлгахад” нь илүү анхаардаг гэдэгт санал нэгдэж байв. Хүүхэд залуусын боловсролд хэн илүү үүрэг хүлээх ёстойг асууж ярилцахад эцэг эх болон хүүхдүүдийн хариултаас нэлээд зөрүүтэй дүн харагдсан юм.

Өөрөөр хэлбэл, эцэг эхчүүдийн 45% нь сургууль багш илүү анхаарч ажиллах ёстой гэж үзэж байхад хүүхдүүдийн 62% нь хүүхэд өөрөө өөртөө илүү анхаарах ёстой гэсэн дүгнэлтийг өгсөн нь сонирхолтой байлаа.

Та эцэг эхтэйгээ өөрийнхөө асуудлаар хэр зэрэг ойлголцож чаддаг вэ?



Судалгаанд оролцсон хүүхдүүдийн зүгээс нийт 62% нь эцэг эхтэйгээ сайн ойлголцож чаддаг гэж хариулт өгсөн нь эерэг үзүүлэлт байв. Үүнээс харахад эцэг эхийн хувьд үр хүүхдэдээ зөв нөлөө үзүүлэхэд хүлээж авах, ойлголцох боломж байгааг харуулж байна.

Судалгааны дүнгээс харахад үр хүүхдээ хүмүүжүүлж боловсруулна гэдэг нь сургалтын байгууллагуудад хамаарах үүрэгтэй ажил гэж ойлгодог хандлага хэвээр байгаа нь харагдаж байна. Тэрчлэн нэгэнт эцэг эх болсон бол төрүүлсэн үр хүүхдээ хүмүүжүүлж төлөвшүүлэх нь чухал гэдгийг ойлгодог боловч бодит ажил хэрэг болгоход чиглэл зорилготой үйлийг хийж чаддаггүй нь судалгаанаас харагдсан юм. Ялангуяа гэр бүлийн таагүй нөхцөл байдал, эцэг эхийн боловсролын түвшин доогуур байдал, өрхийн бага орлого зэргийг үндсэн шалтаг болгож үр хүүхдээ хүмүүжүүлэх явдлыг анхаарлын гадуур орхих нь нэлээдгүй байдаг нь ярилцлагын дүнгээс харагдсан юм.

Юутай ч эцэг эхийн хувьд цаг заваа зөв ашиглаж, хүүхдүүдтэйгээ ойр дотно хамтран ажиллаж, эерэг нөлөө үзүүлж чадах арга хэрэгслийг нас сэтгэхүйд нь тохирсон олон хувилбараар сонгон ажиллах чадвартай байхыг эрхэмлэх хэрэгтэй байна. Эцэг эхийн үг үйлдэл бүхэн хүүхдийн төлөвшил, боловсролд онцгой нөлөөлдгийг ухамсарлаж, хүүхдийнхээ нас, бие, сонирхол, сэтгэлгээний онцлогийг өөрсдийн ажил, амьдрал, боломжтой уялдуулан хүүхдэдээ хандаж чиглэсэн харилцаандаа шинэлэг, хариуцлагатай байх нь эцэг эхийн өмнө тавигдаж буй өнөөгийн шаардлага болж байна. “Эцэг эхүүдэд өдөр тутамд хүүхэдтэйгээ сайн муу, зөв буруу үйлийн талаар хэлэлцэж ярилцах олон сайхан нөхцөл бий. Жишээ нь ном уншиж эсвэл кино үзээд “юу нь зөв, юу нь буруу байсан... талаар ярих зэрэг боломжуудыг ашиглаж байх” (Ариунцэцэг, 2016. т. 165) энгийн мэт боловч ач холбогдолтой аргыг өөрсдийн нөхцөл байдалдаа тохируулан ашиглах нь зүйтэй юм. Эцэг эх үр хүүхдэдээ зөв төлөвшил, сайн боловсролыг олгох нь хүүхдийн төдийгүй монгол хүний хөгжлийн үндэс цаашлаад нийгмийн хөгжлийн эх сурвалж учраас эцэг эхүүд сурган хүмүүжүүлэх эв дүй эзэмших нь чухал байна. Sunny Sea Gold (2015)-ийн дурдсанаар эцэг эх өөрсдөө ямар нэг бэрхшээл, асуудалтай бол үр хүүхдийн хүмүүжил, боловсролын талаар хайхрамжгүй, үл тоомсорлох хандлага их гаргадаг. Өнөөдөр манай эцэг эхүүд хүндхэн сорилттой тулгарч байгаа ч нийгмийн ёс суртахууны доройтлыг гэтлэн давах ухаантай, хүнийг хайрладаг, хүндэтгэдэг, хүлээн зөвшөөрдөг, ойлгодог, уучилдаг, бусадтай хамтарч

чаддаг зэрэг хүний үнэт чанаруудыг хүүхдэдээ төлөвшүүлэх үүргээ хариуцлагатай биелүүлэх хэрэгтэй байна. Судалгааны дүнгээс харахад үр хүүхдээ хүмүүжүүлж боловсруулна гэдэг нь төр засаг, сургалтын байгууллагуудад хамаарах үүрэгтэй ажил гэж ойлгодог хандлага хэвээр байгаа нь харагдаж байна. Тэрчлэн нэгэнт эцэг эх болсон бол төрүүлсэн үр хүүхдээ хүмүүжүүлж төлөвшүүлэх нь чухал гэдгийг ойлгодог боловч бодит ажил хэрэг болгоход чиглэл зорилготой үйлийг хийж чаддаггүй нь судалгааны явцад харагдсан юм. Мөн эцэг эхүүд төр, засгийн зүгээс илүү анхаарч ажиллах ёстой гэж үзэж байхад хүүхдүүдийн хувьд хүүхэд өөрөө өөртөө илүү анхаарах ёстой гэсэн дүгнэлтийг өгсөн нь сонирхолтой байлаа. Юутай ч эцэг эхийн хувьд цаг заваа зөв ашиглаж, хүүхдүүдтэйгээ ойр дотно хамтран ажиллаж, эерэг нөлөө үзүүлж чадах арга хэрэгслийг нас сэтгэхүйд нь тохирсон олон хувилбараар сонгон ажиллах чадвартай байхыг эрхэмлэх хэрэгтэй байна.

Дүгнэлт

Бидний хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд манай эцэг эх өөрсдийн ирээдүй болсон үр хүүхдүүдээ ухаалаг, хариуцлагатай, бүтээлч, боловсролтой, иргэн болгон төлөвшүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байгаа хэдий ч энэ нь нийт түвшинд жигд бус, урсгалаар, зарим талдаа төр, боловсролын байгууллагат даатгах хандлагатай байна. Ийм нөхцөл байдалд хүргэж буй нэлээдгүй хүчин зүйл бидэнд ажиглагдлаа. Тухайлбал ядуурал, ёс суртахууны уналт, гэр бүлийн таатай бус уур амьсгал, багш эцэг эхийн хавсарсан системтэй сурган хүмүүжүүлэх үйл хангалтгүй, хүүхдэд хандах эцэг эхийн чиглэл зорилготой эерэг нөлөөлөл бага байгаа зэрэг нь өнөөгийн үндсэн доголдол бөгөөд энэ чиглэлд олон талын далайцтай арга хэмжээг авах нь чухал байна.

Хүүхэд бүр хамгийн шилдэгт тэмүүлж өсдөг. Энэ их хүслийг хамгийн анх эцэг эх сонсож хуваалцдагийн хувьд үр хүүхдээ зөв, ухаалаг, бие даасан, өөрийгөө хөгжүүлэх чадвартай, амьдралд идэвхтэй, бүтээлч хүн болгон төлөвшүүлэх нь эцэг эх болсон өдрөөс өмнө нь тавигддаг үүрэг, үлгэрлэж төлөвшүүлдэг ухаан гэдгийг тэд ухамсарлах ёстой. Үүнд төр, олон нийт, сургууль зөв удирдлага, сургалтаар чиглүүлж, хамтран ажиллах үүргээ шинэ шатанд хэрэгжүүлэх нь чухал байна. Эцэг эхийн үг үйлдэл бүхэн хүүхдийн төлөвшил, боловсролд онцгой нөлөөлдгийг ухамсарлаж, хүүхдийнхээ нас, бие, сонирхол, сэтгэлгээний онцлогийг

өөрсдийн ажил, амьдрал, боломжтой уялдуулан хүүхдэдээ чиглэсэн харилцаандаа шинэлэг, хариуцлагатай хандах нь эцэг эхийн өмнө тавигдаж буй өнөөгийн шаардлага болж байна.

Ном зүй

Ариунцэцэг, Г. (2016). Ёс суртахууны боловсрол: Ямар ёсыг яаж сургах вэ?, Түүх, нийгмийн ухааны боловсролын онол, арга зүйн асуудал. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, Монгол.

Энхжаргал, Д. (2019, 3 сар). “Хүүхэд, залуусын боловсролд эцэг эхийн оролцоог чанаржуулах нь” судалгаа.

Пүрэв, О. (2013). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. III боть. Улаанбаатар, Монгол: Бит Пресс ХХК.

Raymond A, Horn, Jr. (2002). *Understanding Educational Reform*. Santa Barbara, California, Denver, Colorado, Oxford, England: ABC CLIO.

Sunny Sea Gold, (2015, July 1.). *How to be a better Parent*. retrieved from <https://www.scientificamerican.com/article/how-to-be-a-better-parent/>

Improving parents involvement in their children's education

D.Enkhjargal
NUCB

One of the crucial issues of the modern society is the next generation's education. Parent's role is important for this area. While parents and children were working together on the some creative tasks, we observe that parent's role is not good enough for their children's education in our country. So we intend to clarify parent's involvement in their children's education and the ways to improve parent's initiatives within this paper. Based on a survey taken from 120 parents, it is clear that modern parents have an old attitude that formal organizations like kindergarten and school should pay more attention than parents do.

Although they understand that parents support is a key role in youth education, they do not have ongoing encouragement to fulfill their duties. Particularly, children are left behind parents care due to uncomfortable family situation, parent's poor education and poverty. Our survey includes questions about how many hours a day parents spend for their children and what their attitudes are. Our survey shows interesting results and suggests that parents should make more initiatives to encourage their children's education, social skills and behavior in different ways.

Key words

Youth education, building character, parents involvement